

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

2021.08.13

1. **“Монголросцветмет” ТӨҮГ нь Баяжуулах үйлдвэрийн технологийн хяналт, сорьцлолтын ажил хийх зорилгоор зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөх үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.**

2. **Энэхүү зөвлөх үйлчилгээ нь “Монголросцветмет” ТӨҮГ-ын эзэмшилд буй төмрийн хүдэр, хайлуур жонш, алтны шороон ордын хүдэр болон элс боловсруулах технологийн шат дамжлага бүрт технологийн хяналт, сорьцлолт хийж, зөвлөмж боловсруулан тайлан бэлтгэх зорилготой.**

3. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагуудыг хангаж буйг нотлох дараах баримт бичгийг ирүүлнэ. Үүнд:

- Байгууллагын ерөнхий танилцуулга
- Аж ахуйн нэгжийн гэрчилгээ /хуулбарыг ирүүлэх бол нотариатаар баталгаажуулна/
- Байгууллагын санхүүгийн чадавхын мэдээлэл /сүүлийн 2 жилийн буюу 2019, 2020 оны санхүүгийн тайланг аудитын дүгнэлтийн хамт ирүүлэх/,
- Татвар, нийгмийн даатгалын газар, Шүүхийн шийдвэр гаргах ерөнхий газар/ШШГЕГ/-ын тодорхойлолт зэргийг ирүүлнэ.
- Сүүлийн 3 жилд технологийн хяналт, сорьцлолт гүйцэтгэж байсан туршлагын талаарх мэдээлэл, ажил гүйцэтгэсэн гэрээний хуулбар, тайлангийн хамт ирүүлнэ.

4. Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг санал хүлээн авах эцсийн хугацаанаас нэг хоногийн өмнө ажлын өдрийн 09-16 цагийн хооронд авч болох бөгөөд мэдүүлгийг 2021 оны 08 дугаар сарын 20 – ны өдрийн 10 цагаас өмнө цахим худалдан авах ажиллагааны систем www.tender.gov.mn хаягаар ирүүлнэ.